



I-III/2023

Тархаасан: 2023 оны 4 дүгээр сарын 17



Бүх төрлийн тээврийн орлого өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өслөө

Бүх төрлийн тээвэр

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2023 оны эхний улиралд 22.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 12.3 (2.3 дахин) сая тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 10.5 (4.1 дахин) сая тонноор, төмөр замын тээврээр тээсэн ачаа 1.9 (29.8%) сая тонноор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2023 оны эхний улиралд 31.3 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.6 (7.7%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2021 I-III	2022 I-III	2023* I-III
Тээсэн ачаа, сая тонн	17.0	9.7	22.0
Зорчигчид, сая хүн	19.8	33.9	31.3
Тээврийн орлого, тэрбум төгрөг	351.3	299.1	705.3

Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2023 оны эхний улиралд өмнөх улирлаас 1.2 (5.8%) сая тонноор, зорчигчид 1.4 (4.8%) сая хүнээр тус тус өссөн байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2023 оны эхний улиралд 705.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 406.2 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд агаарын тээврийн орлого 150.9 (3.7 дахин) тэрбум төгрөг, авто замын тээврийн орлого 152.3 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Бүх төрлийн тээврийн орлого 2023 оны эхний улиралд өмнөх улирлаас 39.3 (5.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Авто замын тээвэр

Авто тээврээр 2023 оны эхний улиралд 13.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 10.5 (4.1 дахин) сая тонноор өсжээ. Энэхүү өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 9.4 (3.9 дахин) сая тонноор өссөн нь нөлөөлжээ.

Авто тээврээр 2023 оны эхний улиралд давхардсан тоогоор 30.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9 (8.7%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 2.0 (6.5%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Харин авто тээврээр тээсэн ачаа 2023 оны эхний улиралд өмнөх улирлаас 1.4 (11.6%) сая тонноор, зорчигчид 1.4 (4.8%) сая хүнээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2021 I-III	2022 I-III	2023* I-III
Тээсэн ачаа, сая тонн	8.9	3.4	13.9
Уул уурхайн бүтээгдэхүүн	8.2	3.2	12.6
Зорчигчид, сая хүн	19.8	33.4	30.5
Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчид	17.1	31.5	29.4
Тээврийн орлого, тэрбум төгрөг	129.7	97.2	249.4

Авто тээврийн салбарын орлого 2023 оны эхний улиралд 249.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 152.3 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд ачаа тээврийн орлого өмнөх оны мөн үеэс 140.5 (3.1 дахин) тэрбум төгрөгөөр,


зорчигч тээврийн орлого 11.8 (41.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Харин авто тээврийн орлого 2023 оны эхний улиралд өмнөх улирлаас 17.6 (6.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2023 оны эхний улиралд 8.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.8 (29.8%) сая тонноор өсжээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА,
сараар, мянган тонн



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.4 (96.2%) сая тонн, дотоод ачаа 267.4 (8.6%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2023 оны 3 дугаар сард 2.7 сая тонн болж, өмнөх сараас 157.9 (6.1%) мянган тонноор өссөн байна.

Энэхүү өсөлтөд барилгын материалын тээвэр 24.6 (37.2%) мянган тонн, хар төмрийн тээвэр 20.3 (3.9 дахин) мянган тонн, төмрийн хүдрийн тээвэр 10.6 (2.5%) мянган тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 3. ТӨМӨР ЗАМААР ТЭЭСЭН АЧАА, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар,
бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар


Үзүүлэлт	2021 I-III	2022 I-III	2023* I-III
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	84.7	86.7	92.0
Барилгын материал	9.9	8.1	3.8
Мод, модон материал	0.4	0.5	0.2
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	1.1	0.9	0.7
Түргэн муудах бүтээгдэхүүн	0.05	0.02	0.01
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.3	0.5	1.1
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	0.7	1.3	0.6
Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	0.1	0.1	0.1
Бусад	1.8	1.9	1.5

Төмөр замаар 2023 оны эхний улиралд тээсэн ачаа өмнөх оны мөн үеэс уул уурхайн бүтээгдэхүүн 1.8 (44.9%) сая тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 41.7 (2.7 дахин) мянган тонноор өсөж, барилгын материал 130.5 (35.3%) мянган тонн, хар төмөр 18.9 (32.9%) мянган тонноор буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2023 оны эхний улиралд 490.8 (давхардсан тоо) мянга болж өмнөх оны мөн үеэс 146.8 (42.7%) мянган зорчигчоор өссөн байна. Энэхүү өсөлтөд орон нутгийн зорчигчид 142.9 (41.5%) мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2023 оны 3 дугаар сард 187.1 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 38.3 (25.7%) мянган хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн




Төмөр замын тээврийн орлого 2023 оны эхний улиралд 248.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 103.0 (71.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд нүүрс, төмрийн хүдэр, жонш, жоншны баяжмал, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 14.1 (18.5%) тэрбум төгрөгөөр өсөж 89.9 тэрбум төгрөг болжээ.

Агаарын тээвэр

Агаарын тээврээр тээсэн ачаа 2023 оны эхний улиралд 2.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 519.0 (19.1%) тонноор буурсан байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, сараар, тонн




Агаарын тээврээр 2023 оны эхний улиралд дотоодод 3.6 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4 (10.0%) тонноор буурсан байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 2197.7 тонн болж, өмнөх оны мөн үеэс 518.6 (19.1%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2023 оны 3 дугаар сард 794.1 тонн болж, өмнөх сараас 75.6 (10.5%) тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 10.6 хувиар өссөн нь нөлөөлжээ.

ЗУРАГ 4. АГААРЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн



Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2023 оны эхний улиралд 89.1 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 19.2 (27.5%) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Оюутолгой чиглэлийн зорчигчид 40.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2023 оны эхний улиралд 229.3 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 168.7 (3.8 дахин) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Сүүл чиглэлийн зорчигчид 84.1 мянга, Токио чиглэлийн зорчигчид 15.5 мянга, Бээжин чиглэлийн зорчигчид 9.8 мянга, Бангкок чиглэлийн зорчигчид 9.7 мянга, Станбул чиглэлийн зорчигчид 8.1 мянган хүнээр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2023 оны эхний улиралд 207.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 150.9 (3.7 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Харин агаарын тээврийн орлого 2023 оны 3 дугаар сард өмнөх сараас 400.3 (0.6%) сая төгрөгөөр буурч, 67.9 тэрбум төгрөг болжээ.

Тооцох аргачлал

Ачаа эргэлт: Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километр шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрд харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



Эх үүсвэр:

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2023 оны 7 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Ц.Тэгшжаргал
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч М.Батхишиг
Утас: (976-11)-326414

